

“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ”-ЫН ТУХАЙ ҮЗЭЛ САНААНУУД

*Р.Давааням**

Үндэсний аюулгүй байдлын тухай

Түүхийн бүхий л үед аливаа улс орны өмнө үндэсний аюулгүй байдлаа хэрхэн хангах, хамгаалах, нөлөөнийхөө бүсийг хэрхэн өргөжүүлэх вэ гэдэг асуудал үндэсний төр бий болсон цагаас тулгарсаар, энэ талаар судалсаар ирсэн.

Шинжлэх ухааны салбар бүр тухайн чиглэлээр дагнан судалдаг тухайлбал: Социологи болон сэтгэл зүйн судалгааны салбар нь жирийн бус онцгой үзэгдэл үйл явцад хариулт өгөх, танин мэдэхэд чиглэдэг. Харин хууль хийж болох, хийж болохгүй зүйлсийг зааглаж өгдөг, эдийн засгийн судалгаа нь тухайн үйл явцаас хэрхэн хэд хичнээн хэмжээний ашиг олж болох талаар судалгааг явуулдаг бол үндэсний аюулгүй байдлын судалгаа нь шинжлэх ухааны бүхий л хүрээг хамарсан өргөн хүрээтэй өөрийгөө хэрхэн хадгалан үлдэх, хамгаалах, цаашлаад хөгжүүлэх боломжыг судалдаг. Шинжлэх ухааны бүхий л салбар хүрээг хамарч байдаг өргөн хүрээтэй ойлголт юм.

Үндэсний аюулгүй байдлын судалгаа нь судалгааны эхэн үедээ цэрэг зэвсэг, дайны талаас нь илүүтэй харж судлаж байсан бол яваандаа илүү өргөн хүрээнд олон талаас нь нийгэм, цэрэг зэвсэг болон эдийн засгийн хувьд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг хамруулан судлах байдлаар өргөжиж ирсэн. Өнөө үед аюулгүй байдалд заналхийлж байгаа уламжлалт хүчин зүйлсийн тухай ойлголт хангалтгүй болсон. Энэ нь дэлхий нийтийг хамарсан улс төр эдийн засаг хүрээлэн буй уламжлалт бус хүчин зүйлс гарсантай холбоотой. Тухайлбал: үндэсний аюулгүй байдалд террорист байгууллагууд халдлага, хил дамнасан хориотой барааны худалдаа /хар тамхи худалдаалах/ болон байгалийн гамшиг, хүрээлэн буй орчины сүйрлийн асуудал зэрэг уламжлалт бус хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлөх болсонтой холбоотой юм.

Үндэсний аюулгүй байдлын талаарх үзэл санаанууд

Үндэсний аюулгүй байдал нь олон салбар болон дэд салбаруудаас бүрддэг бөгөөд статистик, физиологи, түүх, эдийн засаг, социологи зэрэг шинжлэх ухааны бусад салбартай холбогддог. Ийм ч учраас үндэсний аюулгүй байдал нь өргөн хүрээтэй ойлголт юм.

Үндэсний улс нь Улс төр, эдийн засаг, цэргийн болон дипломат ажиллагааг хэрэглэн өөрийн оршин тогтнох үйл явцыг үндэсний аюулгүй байдал гэнэ гэсэн энэхүү үзэл санаа нь Дэлхийн 2-р дайны дараагаас АНУ-д идэвхитэй хөгжсөн ч энэхүү үзэл санаа нь¹ үндэсний аюулгүй байдлыг бүрэн гүйцэт тодорхойлсон тодорхойлолт биш бөгөөд өнөөг хүртэл тийм тодорхойлолт гараагүй байна.

Үндэсний аюулгүй байдлыг олон талаас нь тодорхойлсон тодорхойлолт байдаг. Тэдгээрийг он цагийн хэлхээсээр нь товч дурьдвал:

*Р.Давааням - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

- **Walter Lippmann** /1943/² үндэстэн болон дайны тухай авч үзэхдээ үндэсний аюулгүй байдлыг тодорхойложээ. Тэрээр үзэхдээ “Үндэстэн болон үндэсний аюулгүй байдал гэж дайн болон дайны аюул занал тухайн улсын хууль ёсны сонирхолд заналхийлэхгүй байхыг хэлнэ” гэсэн.

- **Harold Lasswell** /1950/³ үндэсний аюулгүй байдлыг зарим гадаад хүчин зүйлтэй нь уялдуулан тодорхойлсон байдаг. Тэрээр “Үндэсний аюулгүй байдлын гол санаа нь гадаад үйл ажиллагааны эрх чөлөө хангагдсан байдал” гэж үзсэн.

- **Arnold Wolfers** /1960/ Тэрээр объектив үзэл санааны үнэт зүйлсийг субъектив хүчин зүйлсээс ялгаж үзсэн. Тэрээр “Ерөнхий утга нь ялгаатай орчинд буй хүнээс ялгаатай үзэл санаа бий болдог. Үндэсний аюулгүй байдлын бодит утга нь аюул занал байхгүй үед субъектив үнэт зүйлс бий болдог бөгөөд тэрхүү эрхэм зүйлс рүү нь халдах бий гэсэн болгоомжлол үргэлж байдаг” гэж үзсэн.

- **Harold Brown** /1983/⁴ “Үндэсний аюулгүй байдлын тухай бодохуй: дэлхийн аюул дахь батлан хамгаалах ба гадаад бодлого” номоо бичсэн. Тус номонд эдийн засгийн болон хүрээлэн буй орчины аюулгүй байдлыг тодорхойлжээ. Тэрээр “Үндэсний аюулгүй байдал түүний гол чадвар /зорилго/ нь газар нутгийн болон үндэсний бүрэн бүтэн байдлыг хадгалах, түүний эдийн засгийн харилцаа дэлхийн нөхцөл байдалтай уялддаг байх мөн Гадны аливаа хүчин зүйлс түүний байгаль орон, байгууллагууд, төрийн удирдлагад нөлөөлөхгүй байх, өөрийн хил хязгаарыг хянаж чаддаг байх” гэж үзсэн.

- **Charles Maier** /1990/⁵ үндэсний аюулгүй байдлыг үндэсний хүчин чадал талаас нь харах оролдлого хийсэн байдаг. Тэрээр “үндэсний аюулгүй байдал гэж өөрийн дотоод болон гадаад орчинд хяналт бүрэн тавьж чаддаг, олонхийн санаа бодлыг нийгмийн санаа бодолд тусгадаг байх явдал. Тэр нь бидний бие даасан болон тусгаар тогтнолын илэрхийлэл болдог. Цаашдаа улам үндэсний аюулгүй байдлыг бий болгож байхыг хэлнэ” гэжээ.

- **“Farlex”**⁶ толь бичигт үндэсний аюулгүй байдлыг “Үндэсний улс оршин байхын тулд эдийн засаг, цэргийн болон улс төр хүч, дипломат үйл ажиллагаагааг үр дүнтэй, өөрт ашигтайгаар ашиглах явдал юм” гэжээ.

АНУ-ын армийн үзэл баримтлалд “үндэсний аюулгүй байдал хангах арга хэрэгсэл нь АНУ-ын гадаад харилцаа болон үндэсний батлах хамгаалах хамтын үйл ажиллагаа юм” гэж заасан. АНУ-ын батлан хамгаалах үйл ажиллагаа нь дараах хэсгүүдээс бүрдэхийг дурьдсан. Үүнд:

- Цэрэг батлах хамгаалахын хувьд аливаа улс болон улсуудын нэгдлээс давуутай байх

- Гадаад таатай нөхцөл байдалтай байх

- Чадварлаг батлан хамгаалах үйл ажиллагаа, ил, далд, дотоод, гадаадын хорлон сүйтгэх дайсагнасан алив үйл ажиллагааг амжилттай, чадварлаг батлан хамгаалах⁷ явдал юм гэсэн байна.

Дээрх тодорхойлолтуудаас харахад үндэсний аюулгүй байдлыг бүрэн гүйцэд тодорхойлсон тодорхойлолт хараахан байхгүй бөгөөд аливаа нэг

хүчин зүйлсийг нь гол болгосон тодорхойлолтуудыг түгээмэл хэрэглэж байна. Дүгнэн үзвэл “хүйтэн дайны” үед улс гүрнүүдийн хооронд гарч болзошгүй мөргөлдөөний тухай үзэл баримтлал ойлголтын үндсэн дээр буюу улс орны хил хязгаартай холбон үзэж гол төлөв зэр зэвсгийн хүчинд тулгуурлаж аюулгүй байдлаа хамгаалах арга хэмжээ авахтай холбон тайлбарлаж ирсэн. Өнөөдөр 21-р зуунд ийм тодорхойлолт, үзэл бодол парадигм өөрчлөгдөж байна.⁸ Өнөөдөр аюулгүй байдалд ухамсартайгаар болон ухамсаргүйгээр, зориуд болон зориуд бусаар нөлөөлөх, нөлөөлөл, аюул заналыг харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг хэлнэ⁹ гэж үзэж байна.

Жижиг орны хувьд аюулгүй байдалаа хэрхэн үр дүнтэй, оновчтой тодорхойлох нь оршин байх хамгийн гол үндсэн баталгаа болно. Бага буурай орнуудын хувьд үндэсний аюулгүй байдлаа хэт ерөнхий байдлаар тодорхойлох нь аюулгүй байдлыг хангах бодлого цэгцтэй, тууштай байх зарчмыг саармагжуулах үндэс болдог.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай

Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ¹⁰ гэж заасан бөгөөд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана¹¹ зэргээр заасан.

Уг тодорхойлолт нь хэт ерөнхий жижиг орны хувьд аюулгүй байдлын үндсийг бүрэн дүүрэн тодорхойлж чадахгүй гэж үзэж байна. Тухайлбал: Монгол Улсын язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай байдлыг хангахыг зорих үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлох нь илүү үр дүнтэй. /Олон улсын харилцаанд тухайн нэг орны гадаад, дотоод таатай нөхцөл байдал бүрэн хангагдана гэсэн ойлголт байхгүй харин хангах чиглэлээр үйл ажиллагааг явуулах гэсэн ойлголт л байдаг. Дээр дурьдагдсан “хангагдсан байдал” гэдэг талаас нь авч үзвэл Монгол Улсын үндэсний аюулгүй байдал хүч чадашгүй хийсвэр томъёолол болохоор байна/ Мөн тус баримт бичигт үндэсний язгуур ашиг сонирхолын дотор монголын ард түмний соёл иргэншил оршин тогтох гэсэн томъёолол байдаг. Соёл иргэншлийн асуудлыг судлаачид дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

- Соёл иргэншил буюу civilization гэсэн үг нь иргэн буюу civilian гэсэн үгтэй холбоотой. Тэгээд үгийн этимологиор нь хөөгөөд үзэх ахул civilian гэдэг нь эртний Грекийн хот-улсуудын нэг болох Civiс-т амьдардаг хүмүүсийг хэлдэг байжээ. Тэгэхээр соёл иргэншил гэдэг бол суурьшил улмаар хот (онцлов) гэсэн үзэгдэлтэй гарцаагүй холбоотой. Хэн, хэзээ суурьшиж чадах вэ гэвэл байгалиасаа зохих хэмжээгээр хараат бус болсон, өөрөөр хэлбэл, нэг газраас амьжиргааны эх үндсийг олж чаддаг болсон үед (Энд газар

тариалангийн тухай яригдаж байгааг та тааварлаж буй биз ээ) суурьшиж хотоо байгуулна. Энэ газар философи, хими, физик, математик, урлаг илүү хөгжиж, хуулиар амьдрах шаардлага гардаг. Үүнийг соёл иргэншил хэмээнэ¹² гэсэн бол нөгөө талаас нь

- Соёл гэдэг бол аливаа улс орны онцлог шинж төрхийг харуулдаг зүйл ба харин соёл иргэншил бол дэлхий нийтийн зүйл болж байдаг¹³ гэж үзсэн. Мөн манай зарим судлаачид монгол нь нүүдлийн соёл иргэншилтэй гэж үздэг. Дэлхий дахинд оршин байгаа нүүдлийн болон суурин соёлын нүүдлийн соёлыг хамгаалах хадгалах нь монгол улсын үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үндэс болох гэсэн асуудал гарна. Иймээс соёл иргэншил гэдэг томъёоллыг ашиглахдаа илүү бодитойгоор авч үзэх шаардлагатай юм.

Мөн үндэсний аюулгүй байдлын тодорхойлолтод “оршин тогтнох”, Монгол Улсын “тусгаар тогтнол”, “бүрэн эрхт байдал”, “нутаг дэвсгэр”, “хил хязгаарын халдашгүй байдал”, “бүрэн бүтэн байдал” гэсэн ойролцоо утгатай давхцсан санаануудыг ихээр оруулсан нь шинжлэх ухаанч байдлаар биш илүүтэй хэлбэр хөөсөн байдлаар томъёолох оролдлого хийсэн мэт ажиглагдаж байна.

Эцэст нь “эдийн засгийн бие даасан байдал”, “экологийн тэнцвэрт хөгжил” гэсэн нэр томъёог мөн оруулсан нь даяаршиж байгаа дэлхий ертөнцөд дангаараа нэг эдийн засаг бие даан орших боломжгүйг дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн хямрал сануулсаар байна. Дээрхээс харвал үндэсний аюулгүй байдлыг илүү бодитой, прагматик байдлаар томъёолох, аюулгүй байдлыг тууштай хангах нэгдсэн, уламжлалт бодлого явуулах зайлшгүй шаардлага байсаар байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. /http://en.wikipedia.org/wiki/National_security/
2. 1889-1974 was an American оюунлаг, зохиолч, сурвалжлагч, илтгэгч, улс төрийн тоймч, судлаач/
3. (1902-1978) АНУ-ын улс төр судлаачдын тэргүүний улс төр судлаачдын төлөөлөл/
4. АНУ-ын батлах хамгаалахын нарийн бичгийн дарга асан /1977-1981/
5. Harvard-ийн их сургуулийн багш профессор
6. /төлбөргүй онлайн толь бичиг бөгөөд дэлхийн хамгийн түгээмэл олон салбарыг хамарсан иж бүрэн толь бичигт тооцогддог <http://www.thefreedictionary.com>
7. <http://www.thefreedictionary.com/national+security>
8. Field J.P /So Authors/ National security and CIA pp.2 2001-USA
9. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гуравдагч түнш орнууд УБ. 2003. 35 дахь тал
10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1-1-1
11. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1-1-2
12. Дэлхийн түүх номны 54-55-р тал
13. Монголын соёл иргэншил А.Цанжид